



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 02 дугаар сарын 20

№ 06/15

Улаанбаатар хот

「ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ」
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
ТАНАА

Комисст хандаж Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч
2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/149 дүгээр албан бичгээр Цагдан
хорих 461 дүгээр Хаалттай ангийн дарга, хурандаа тус Холбоонд
хүргүүлсэн мэдэгдэлд хоригдогч, өмгөөлөгч нарын биечлэн уулзах уулзалтыг хязгаарлаж,
утсан харилцаа холбоогоор дамжуулж уулзуулахаар зохион байгуулалтын арга хэмжээ
авч байгаа нь Өмгөөллийн тухай хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон
улсын пакт, НҮБ-ын наймдугаар Конгрессоос баталсан Өмгөөлөгчийн үүргийн талаарх
үндсэн зарчим зэрэг баримт бичгийн заалтуудыг ноцтой зөрчсөн, хүний эрх
хамгаалагчийн болон хүний эрхийг дордуулсан, өмгөөллийн нууц, өмгөөлөгчийн
мэргэжлийн үйл ажиллагааны баталгааг алдагдуулсан хууль зөрчсөн үйлдэл гэж үзсэн
тул энэхүү үйлдэл нь хүний эрх зөрчиж буй эсэхэд дүгнэлт өгч, хамтран ажиллах талаар
хүсэлт ирүүлжээ.

Дээрх хүсэлт нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7
дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамаарах асуудал гэж үзэж, хоригдогчийн өмгөөлөгчтэйгөө
ганцаарчлан уулзах болон хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийн өнөөгийн
байдлын талаар 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Хүний эрхийн Үндэсний Комисс,
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монголын Өмгөөлөгчдийн Холбоог
оролцуулсан гурван талт уулзалт, 2023 оны 02 дугаар сарын 02, 14-ний өдөр Цагдан
хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн хоригдогч өмгөөлөгчтэй уулзах хэсгийн нөхцөл
байдалтай газар дээр нь танилцах, эрх бүхий албан тушаалтан, өмгөөлөгч, хоригдогч
нарын төлөөлөлтэй ярилцлага хийх, тайлбар гаргуулан авах, холбогдох албан бичиг,
судалгаа, үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг судлах ажиллагаа явууллаа.

Өмгөөлөгчид хоригдогчтой уулзах үедээ Өмгөөллийн тухай хууль, Шүүхийн
шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, хорих
байгууллагын аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм журмыг удаа дараа зөрчиж
утсаар яриулах, гар утас нууцаар оруулах, уулзалтын өрөөний цонхоор тамхи, мөнгө
болон бусад хориотой эд зүйлс нэвтрүүлэх, нэвтрүүлэхийг завдах зэрэг зөрчлийг таслан
зогсоох зорилгоор өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах арга хэмжээг утсан харилцуур
ашиглаж зохион байгуулахаар шийдвэрлэжээ. Тухайлбал, 2023 оны 01 дүгээр сарын
байдлаар буюу нэг сарын хугацаанд дээр дурдсан 28 зөрчлийг нэр бүхий өмгөөлөгч
гаргасан нь баримтаар тогтоогдсон байна. Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих
ангийн зүгээс зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод хяналт

150070052

шалгалт, өрөө тасалгааны орчныг сайжруулах, эд зүйл дамжуулах боломж нөхцөлийг хязгаарлах чиглэлээр тодорхой арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн боловч зөрчил гаргасан өмгөөлөгчдийн талаарх мэдээллийг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд мэдэгдэх арга хэмжээ авдаггүй нь зөрчил дахин үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги хоригдол, хоригдогчтой ажлын 5 өдөрт 160-490 өмгөөлөгч 475-490 орчим хоригдогчтой (давхардсан тоогоор) уулзалт хийхэд өрөөний багтаамжаас шалтгаалан өмгөөлөгч 30 минутаас 2 цаг орчим зарим тохиолдолд түүнээс дээш хугацаагаар хүлээдэг байсныг шийдвэрлэх зорилгоор 6 өрөөг 8 тасалгаа бүхий том өрөөгөөр сольж, шинээр цахимаар уулзах 4 тасалгааг нэмж нийт 12 өмгөөлөгч зэрэг уулзах боломжийг бүрдүүлэх мөн цагдан хорих байранд цахим шүүх хуралдааны өрөөнд шинээр 4 тасалгаа бүхий өрөөг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ашиглалтад оруулсан нь сайшаалтай байна.

Тус ангийн хоригдогч, өмгөөлөгч нарын уулзалтын өрөөтэй танилцахад акустик хавтангаар доторлож дуу чимээг гадна орчноос тусгаарласан, тус бүрдээ хаалгатай, уулзалтын өрөөнд харилцуур утас байршуулсан, утсан харилцаа нь кодоор холбогддог, шилэн тусгаарлалт бүхий хаалттай, сууж ярих боломжтой, хөдөлгөөн хязгаарлагдсан, хоригдогч талын тасалгаанд хяналтын дүрсний камер байршуулсан, битүүмжлэл сайтай байдлаар тохижуулжээ. Шилээр тусгаарлалт хийсэн нь түүнийг хагалж хоригдогч өөртөө болон бусдад гэмтэл учруулах, утсан харилцуурыг олон хүн ашиглаж байгаагаас шалтгаалан хорих ангид халдварт өвчин тархах, утсан харилцуурын төхөөрөмж, шугам сүлжээг ашиглан яриаг чагнах, нууцлал алдагдах эрсдэлтэй байж болзошгүй байна.

Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн удирдлагаас өгсөн тайлбарт утсан харилцуур ашиглах нь яриа чагнах ямар ч боломжгүй, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөн шалгах нууц ажил явуулах, утсан харилцааг чагнах арга хэмжээ нарийн зохицуулагдсан. Манай байгууллагын зүгээс хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулахгүй, зөвхөн гарч байгаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой гэжээ. Харин Монголын Өмгөөлөгчдийн Холбооны зарим өмгөөлөгчдөөс харилцуур утсаар харилцахад бэрхшээл хүндрэл үүсэж байгаа эсэх талаар тодруулахад өмгөөлөгч П.У-гийн хувьд хоригдогчтой уулзахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл гардаггүй гэсэн бол өмгөөлөгч Н.М, Б.Б, Г.Н нарын хувьд нууцлалыг хангасан эсэхэд эргэлзэж байгаа, нууцлал алдагддаг, ганцаарчлан уулзах агуулгад нийцэхгүй, айдастай байдаг талаар сэтгэгдлээ илэрхийлж байсан.

Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн хувьд хоригдогчидтой хийх эргэлт уулзалтыг зохион байгуулах, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагаас ирж тайлбар мэдүүлэг авах ажиллагаанд дэмжлэг үзүүлж тогтмол ачаалалтай ажилладаг бөгөөд зарим тохиолдолд өмгөөлөгчид үйлчлүүлэгчтэйгээ уулзахад хүлээх, өрөө тасалгаа хүрэлцэхгүй байх тохиолдол гардаг байна. Зарим өмгөөлөгчид хууль зүйн туслалцаа үзүүлэхгүй, хоригдогчдыг агаарт гаргах, салхилуулах зорилгоор дуудаж өрөө тасалгааг удаан хугацаагаар ашиглах тохиолдол түгээмэл гардаг нь зохиомол ачаалал үүсгэж, улмаар бусад хоригдогчдын өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах эрхийг хөндөж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрч байсан нь анхаарал татаж байлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад "...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг

хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй: ... (b) өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгөө харилцах; ...”, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Өмгөөлөгч цагдан хоригдсон яллагдагчтай ганцаарчлан уулзах өрөө нь харилцааны нууцлалыг хангасан байна.”, Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “Үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах боломжоор хангагдах”, мөн НҮБ-ын Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмуудын 8 дахь хэсэгт “Баривчлагдсан, саатуулагдсан, шоронд хоригдсон бүх этгээдүүд, хуульчтай уулзах зохих боломж, хугацаа нөхцөл, түүнтэй саадгүй, бусдын оролцоогүй, хяналтгүйгээр бүрэн ганцаарчлан харьцах, зөвлөлдөх, ийм зөвлөгөөнийг хууль хэрэгжүүлэх албан тушаалтны дэргэд, гэхдээ сонсох боломжгүйгээр хийлгэх явдлыг хангах ёстой”, 22 дахь хэсэгт “Засгийн газар нь хуульчид, тэдний харилцагчдаас мэргэжлийн харилцааныхаа хүрээнд харилцах аливаа харьцаа, зөвлөгөөний нууц шинж чанартай байхыг хүлээн зөвшөөрч хангах ёстой” гэж тус тус заасан.

Дээр дурдсан зохицуулалтад өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах боломжийг хязгаарлах болон утсан харилцуур хэрэглэхийг зохицуулаагүй. Энэ тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ” гэж заасныг баримтална.

Хоригдогч өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах уулзалтыг утсан харилцуур ашиглаж зохион байгуулахаар шийдвэрлэж хэрэгжүүлсэн, цагдан хорих төвд хоригдогч өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах өрөөний нэгдсэн стандарт байдаггүй, өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэх горим тогтоогүй байдал нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, олон улсын эрх зүйгээр баталгаажуулсан өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах, хувийн нууцтай байх эрхийг зөрчиж болзошгүй байна.

Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Төв, орон нутгийн хэмжээнд цагдан хорих байранд хоригдогч өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах уулзалтыг утсан харилцуур ашиглаж зохион байгуулахгүй байх;
2. Цагдан хорих байранд хоригдогч өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзахад зориулсан “Уулзалтын өрөө”-ний стандартыг батлан мөрдүүлэх, ингэхдээ Монголын Өмгөөлөгчдийн Холбооны саналыг харгалзах, хоригдогчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээг тусгасан байх;
3. Хоригдогч өмгөөлөгч, гэр бүлийн гишүүдтэйгээ биечлэн уулзах боломжит бүх тохиолдлыг хязгаарлахгүй байх, зөвхөн өөрийнх нь зөвшөөрснөөр цахимаар уулзуулах арга хэмжээг хэрэгжүүлж байх;
4. Хүний эрхийн Үндэсний Комисс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны уулзалтаар хөндөгдсөн хоригдогчдын хууль зүйн туслалцаа авах эрхийн анхаарал татсан бусад асуудлыг шийдвэрлэх. Тухайлбал, салхилгааны өмгөөлөгч гэх мэт;
5. Өмгөөлөгч хоригдогчтой уулзах үедээ холбогдох хууль тогтоомж, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм зөрчсөн талаарх мэдээллийг Монголын Өмгөөлөгчдийн


Холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд тухай бүр мэдээлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх;

6. Монголын Өмгөөлөгчдийн Холбооны удирдлага, гишүүдтэй тодорхой давтамжтайгаар уулзалт зохион байгуулж, хорих анги, цагдан хорих байранд хоригдогчдын хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудлаар мэдээлэл солилцох, анхаарал татсан асуудлыг шийдвэрлэж байх:

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох баримтын хамт 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Хүний эрхийн Үндэсний Комисс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гурван талт уулзалтын тэмдэглэл, Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд хүргүүлсэн зөвлөмжийн хуулбарыг хүргүүлэв.

Хавсралт ¹⁶ хуудастай.

ГИШҮҮН  Б.ЭНХБОЛД